2019 оны 05 сарын 29-ний өдөр Дугаар А/507 Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 23/15 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2019 онд санхүүжүүлэх нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад ухаалаг систем нэвтрүүлэх ажлын жагсаалтыг 1 дүгээр, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад харилцаа холбооны тоон технологи нэвтрүүлэх ажлын жагсаалтыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2.Энэхүү захирамжийн 1 дүгээр зүйлд заасан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрхийг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар /Э.Болормаа/-т шилжүүлэн, худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, дүнг танилцуулж ажиллахыг даалгасугай.

3.Энэ захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг гүйцэтгэлээр нь санхүүжүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Э.Ганхүү/-т, захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Мэдээлэл, технологийн газар /О.Чинзориг/-т, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшилт, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар /Ч.Однасан/-т тус тус даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ С.АМАРСАЙХАН

Нийслэлийн Засаг даргын 2019 оны
05 дугаар сарын 29-ний өдрийн
А/507 дугаар захирамжийн 1 дүгээр
хавсралт

НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДАД
УХААЛАГ СИСТЕМ НЭВТРҮҮЛЭХ АЖЛЫН ЖАГСААЛТ

д/д	Төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төсөвт өртөг /сая төгрөг/
1	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын мэдээллийн санг өргөжүүлж, цахим үйлчилгээний дэд бүтэцтэй холбон нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх	200.0
2	"Албан хэрэг хөтлөлтийн систем, Байгууллагын архивын систем"-ийн нэмэлт хөгжүүлэлт, тоон гарын үсгээр баталгаажсан цахим албан хэрэг хөтлөлтийг хэрэглээнд нэвтрүүлэх	25.0
3	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад хэрэглэгдэх цогц систем /платформ/-ийг хөгжүүлэх	275.0
Нийт төсөв		500.0

Нийслэлийн Засаг даргын 2019 оны
05 дугаар сарын 29-ний өдрийн
А/507 дугаар захирамжийн 2 дугаар
хавсралт

НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДАД
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТООН ТЕХНОЛОГИ НЭВТРҮҮЛЭХ
АЖЛЫН ЖАГСААЛТ

д/д	Төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төсөвт өртөг /сая төгрөг/
1	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын мэдээллийн сангийн тоног төхөөрөмжийн хүчин чадлыг сайжруулж, нэмэгдүүлэх	135.0
2	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлыг хангах, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг сайжруулах	245.0
3	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын харилцаа холбооны тоон технологийн тоног төхөөрөмжийн сайжруулах	120.0
Нийт төсөв		500.0